



**НИЙСЛЭЛИЙН
СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 1/58

Улаанбаатар хот

“Нийтийн биеийн тамир,
спортын хөгжил, цаашдын чиг хандлага”
сэдэвт бага хурлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05, 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл дэх “Нийтийн биеийн тамир, спортын хөгжил, цаашдын чиг хандлага” сэдэвт судалгаа шинжилгээ, онол практикийн бага хурлыг 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Засгийн газрын 11 дүгээр байрны хурлын танхимд зохион байгуулсугай.

2. Судалгаа шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Судалгаа шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгуулахад шаардагдах 1.950.000 /нэг сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг Нийслэлийн спортын хорооны уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Судалгаа шинжилгээ, онол практикийн бага хурлын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБОЛД

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны
...11... сарын 19...-ны өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
58

“Нийтийн биеийн тамир, спортын хөгжил,
цаашдын чиг хандлага” сэдэвт судалгаа шинжилгээ,
онол практикийн бага хурлыг
зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Хуралд оролцогчдын шагнал: 3 x 100.000 төг = 300.000 төг 3 x 80.000 төг = 240.000 төг 3 x 60.000 төг = 180.000 төг	720.000
2.	Багийн шагнал	300.000
3.	Шүүгчдийн ажлын зардал: /5 хүн x 1 өдөр x 50.000 төг/	250.000
4.	Заал талбайн зардал	300.000
5.	Анонс	150.000
6.	Цом, өргөмжлөл	230.000
Нийт дүн		1.950.000

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны
.....11.09.2019..... сарын 05-ны өдрийн
А/сг дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Нийтийн биеийн тамир, спортын хөгжил,
цаашдын чиг хандлага” сэдэвт судалгаа, шинжилгээ,
онол практикийн бага хурлыг
зохион байгуулах шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|--------------|
| 1. Ерөнхий шүүгч | А.Болдмаа |
| 2. Шүүгч | Л.Алтанцэцэг |
| 3. Шүүгч | Л.Туяа |
| 4. Шүүгч | Ш.Долгор |
| 5. Шүүгч | Ц.Ганбаатар |